



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/175

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37. дэх хэсгийг тус тус үндэслэн "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.3.12 дахь зорилтын 2.3.12.1 дэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан "Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэл"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т даалгасугай.

3. "Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэл"-ийг орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг тооцож, холбогдох арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу санхүүжүүлэх, жил бүрийн төсөв тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б. Батцэцэг)-т даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл)-т даалгасугай.

6. Энэхүү тушаал баталсантай холбогдуулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Хөтөлбөр батлах тухай" А/756 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л. ЭНХ-АМГАЛАН



14241 0611

## НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

XXI дүгээр зуунд шинээр бий болж буй технологи, байгаль орчин, нийгмийн өөрчлөлтүүд, мөн цар тахлын үр нөлөөнөөс үүдэн дэлхийн улс орнуудад тохиолдож буй эдийн засгийн хямрал, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил нь хүнийг аливаа өөрчлөлтөд дасан зохицдог, асуудалд бүтээлчээр ханддаг, ялангуяа насан туршдаа сурч хөгждөг байхыг шаардаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2015 оны Ерөнхий Ассамблейн 70-р чуулганаар баталсан "Тогтвортой Хөгжлийн Зорилгууд" (Sustainable Development Goals) хөтөлбөрийн 17 зорилго, 169 зорилтын хүрээнд анх удаа насан туршийн суралцахуйн асуудал тусгагдсан. "Чанартай боловсролыг дэмжих" гэсэн Зорилго 4-д чанартай боловсролыг анхаарлын төвд тавьж, бүгдийг хамарсан, "хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих" зорилгыг дэвшүүлсэн.

Мөн "Алсын Хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын Зорилт 2.1-д "Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж, бүрдүүлж, боловсролын хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа тасралтгүй суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ" гэсэн зорилгыг дэвшүүлсэн.

"Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)"-ийн Зорилт 1.2-д "Иргэдэд насан туршдаа суралцах боломжийг олгож боловсролын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх" чиглэлээр боловсролын бүх түвшинд иргэдийн насан туршдаа суралцахуйд дэмжлэг үзүүлэх, суралцахуйн хэлбэр, төрөл, агуулгыг мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэх, санхүүжилтийг тодорхой болгож, баталгаажуулах, удирдан чиглүүлэх, хүний нөөцийн чадавх бэхжүүлэх, суралцахуйн үр дүн, өмнө эзэмшсэн мэдлэг, ур чадварыг нь хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх тогтолцоог бий болгож, насан туршдаа суралцахуйн мэдээлэл, бүртгэл, баталгаажуулалтын удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хуульд "насан туршийн суралцахуй" гэж хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг авч үзэн, боловсролын бодлого, үйл ажиллагаа нь насан туршийн суралцахуйг дэмжих зарчмыг баримтлахаар хуульчилсан.

Иймд насан туршийн суралцахуйн олон улсын чиг хандлага, Монгол хүний хөгжлийн хэрэгцээг хангах, нийгмийн хөгжлийн бодлогод нийцүүлэн эдийн засаг, нийгмийн бүхий л хэсгийг хамарсан, хэрэгжихүйц, албан, албан бус, амьдрах орчноос суралцахуйн хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн, бүх нийтэд нээлттэй, уян хатан насан туршийн суралцахуйн хөгжлийн тэргүүлэх чиглэл /үзэл баримтлал/-ийг боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон.

Ингэснээр Монгол Улс хүний хөгжлийг хангасан, нийгмийн хөгжлийн бодлого, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсын чиг хандлагыг баримжаалсан насан туршийн суралцахуйн тогтолцоог хөгжүүлэх боломж бүрдэнэ.

## **ХОЁР. НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ЗОРИЛТ**

2.1 Энэхүү тэргүүлэх чиглэл нь Монгол Улсад насан туршлаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлэх зорилготой.

2.2 Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 2.2.1. тэгш хүртээмжтэй, нээлттэй байх;
- 2.2.2. хүн төвтэй, хүний эрхэд суурилсан байх;
- 2.2.3. боловсролын үндэсний шаталсан бүтцэд нийцсэн байх;
- 2.2.4. суралцахуйн олон хэлбэр, боломж, орон зайг хамарсан байх;
- 2.2.5. хамтын оролцоо, хамтын хариуцлагад суурилсан байх.

2.3 Насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

2.3.1. бүх насны иргэдийг албан, албан бус боловсрол, амьдралын орчинд суралцах эрх тэгш боломжийг бүрдүүлэх, боловсрол, сургалтын нээлттэй, уян хатан, орон зай, цаг хугацаанаас үл хамаарах цахим системийг, контентын санг үе шаттай нэвтрүүлэх;

2.3.2. иргэд насан туршдаа суралцахад дэмжлэг үзүүлэх, удирдан чиглүүлэх үндсэн чиг үүрэг бүхий институцийн тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах;

2.3.3. иргэдийн насан туршдаа суралцахуйд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тогтолцоог бусад салбартай хамтран бэхжүүлэх, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн дэмжлэгийг бий болгох;

2.3.4. насан туршдаа суралцах боломжийг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох;

2.3.5. иргэд албан бус боловсролоор мөн амьдралын орчинд бие даан суралцаж эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамжийг хүлээн зөвшөөрөх, албан боловсролын үр дүнтэй дүйцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох талуудтай хамтран хамтран зохион байгуулах;

2.3.6. иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх, иргэдийн суралцахуйг мөшгөдөг болох.

## **ГУРАВ. НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

3.1 Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд товлосон зорилт бүрийн хүрээнд 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7-д заасан тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.2. Бүх насны иргэдийг албан, албан бус боловсрол, амьдралын орчинд суралцах эрх тэгш боломжийг бүрдүүлэх, боловсрол, сургалтын нээлттэй, уян

хатан, орон зай, цаг хугацаанаас үл хамаарах цахим системийг, контентыг санг үе шаттай нэвтрүүлэх зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.2.1.бага, балчир насны хүүхдийн хөгжлийг гэр бүлд нь суурилан хөгжүүлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг сургалтад хамруулах, шаардлагатай цахим сургалт, зөвлөгөөг өгөх;

3.2.2.сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын насны хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамруулахад холбогдох сургалтын байгууллагатай хамтран ажиллах, нэг ч хүүхдийг орхигдуулахгүй байх арга хэмжээ авах, шаардлагатай бол дэмжих үйлчилгээг холбогдох талуудтай хамтран үзүүлэх, боловсрол нөхөн эзэмшихэд дэмжлэг үзүүлэх;

3.2.3.насанд хүрэгсэд цаг хугацаанаас үл хамааран уян хатан хэлбэрээр мэргэжлийн, техникийн болон дээд боловсролын албан, албан бус сургалтад хамрагдах, бие даан мэргэжлийн ур чадвар, чадамж эзэмших, хувь хүний хөгжлийн сургалт, бусад үйл ажиллагаанд хамрагдах, ажлын байранд, цахимаар суралцах боломжийг нэмэгдүүлэх, ингэхдээ зорилтот бүлгийн насанд хүрэгсдийг нэн тэргүүнд хамруулах;

3.2.4.насанд хүрэгсэд дараах чиглэлийн албан бус сургалт, амьдралын орчинд суралцах үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах, үүнд

- 3.2.4.1.бичиг үсгийн боловсрол;
- 3.2.4.2.үндэсний болон орон нутгийн онцлог соёл, уламжлалыг өвлүүлэх;
- 3.2.4.3.цахим ур чадварыг хөгжүүлэх;
- 3.2.4.4.хөдөлмөр эрхлэх, амьдрах ухааны ур чадварыг хөгжүүлэх;
- 3.2.4.5. эрүүл амьдралын дадал зуршлыг төлөвшүүлэх;
- 3.2.4.6.хууль эрх зүйн ойлголт, мэдлэг олгох, авилгаас сэргийлэх;
- 3.2.4.7.хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэг олгох зэрэг болно.

3.2.5.сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын насны танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд цахимаар суралцах боломжийг олгох, шаардлагатай хөрөнгө оруулалт хийх;

3.2.6.гадаад дахь Монгол иргэдийн суралцахуйг дэмжих;

3.2.7.залуучуудын хэрэгцээнд суурилсан хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, тэднийг нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах, дэмжих, урамшуулах, хөгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, их, дээд сургуультай хамтран зохион байгуулж, хэвших;

3.2.8.иргэдэд бусдын ялгаатай хэрэгцээг ойлгон хамтран ажиллах, харилцан суралцах, хүн бүрд хүртээмжтэй, тэгш, сайн сайхан нийгмийг ойлгуулахад чиглэсэн сургалт, зөвлөгөө, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2.9.малчдын хөгжлийг дэмжсэн хөтөлбөр, үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх.

3.3. Иргэд насан туршдаа суралцахад дэмжлэг үзүүлэх, удирдан чиглүүлэх үндсэн чиг үүрэг бүхий институцийн тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.3.1.насан туршийн боловсролын одоогийн төвүүдийг өөрчлөн зохион байгуулах, чиг үүрэг үйл ажиллагааг шинэчлэх;

3.3.2. насан туршийн суралцахуйн хүний нөөцийн менежмент, чадавхыг сайжруулах.

3.4. Иргэдийн насан туршдаа суралцахуйд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тогтолцоог бусад салбартай хамтран бэхжүүлэх, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн дэмжлэгийг бий болгох зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.4.1.насан туршийн суралцахуйн санхүүжилтийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжүүлэх;

3.4.2.зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлж, суралцах боломжийг дэмжсэн санхүүгийн дэмжлэг (ваучер, сургалтын зээл, гэх мэт)-ийг бий болгоход холбогдох талуудтай хамтран ажиллах;

3.4.3.салбаруудын хамтын оролцоотой санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх.

3.5. Насан туршдаа суралцах боломжийг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.5.1.зорилтот бүлгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад албан, албан бус боловсролд хамрагдах, бие даан сурч хөгжихөд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

3.5.2.суралцагч хот, аймаг, дүүрэг, сум, байгууллагыг төлөвшүүлэх.

3.6. Иргэд албан бус боловсролоор мөн амьдралын орчинд бие даан суралцаж эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамжийг хүлээн зөвшөөрөх, албан боловсролын үр дүнтэй дүйцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох талуудтай хамтран хамтран зохион байгуулах зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.6.1.мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сурталчлан таниулах;

3.6.2.насанд хүрэгсдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжийг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулахад боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

3.7. Иргэдийн насан туршдаа суралцахуйн удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх, иргэдийн суралцахуйг мөшгөдөг болох зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлийг баримтална:

3.7.1.иргэдийн боловсрол, сургалтад хамрагдалтын мэдээллийн сан үүсгэх;

3.7.2.албан, албан бус боловсрол, сургалтын мэдээллийн сан үүсгэж, иргэд хандах боломжийг нэмэгдүүлэх;

3.7.3.удирдлага, мэдээллийн нэгдсэн систем бий болгох.

## **ДӨРӨВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

4.1. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгдсэн

удирдлагаар хангаж, салбарын яамдын саналыг тусгасан хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

4.2. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасан нэгж, нэгжийн удирдлага, боловсролын байгууллага, бүх түвшний боловсролын сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн зэрэг оролцогч талууд хэрэгжүүлж, хамтран ажиллана.

## **ТАВ. САНХҮҮЖИЛТ**

5.1. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- 5.1.1.улсын төсөв;
- 5.1.2.орон нутгийн төсөв;
- 5.1.3.гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр;
- 5.1.4.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

5.2. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх зардлын төсвийг хөтөлбөр, арга хэмжээгээр төсөвлөн, гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэн жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгана.

## **ЗУРГАА. ХҮРЭХ ҮР ДҮН**

6.1. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1.сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын насны хүн амын боловсролд хамрагдалтад ахиц гарсан байна.

6.1.2.боловсрол, сургалтад хамрагдсан насанд хүрсэн иргэдийн эзлэх жин нэмэгдсэн байна.

6.1.3.эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамжаа хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан 25-аас дээш насны хүн амын эзлэх жин нэмэгдсэн байна.

6.1.4.насан туршийн суралцахуйн төвийн удирдлага, ажилтнуудын ажил мэргэжлийн стандарт, ажил үүргийн эрх зүйн орчин бүрдэж, төвийн үйл ажиллагаанд оролцсон орон нутгийн иргэдийн эзлэх жин нэмэгдсэн байна.

6.1.5.нэг иргэнд ногдох боловсрол, сургалтад зарцуулсан санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

6.1.6.насан туршдаа суралцахуйн удирдлага, мэдээллийн системтэй болсон байна.

6.1.7.Монгол Улсын хүний хөгжлийн индексэд ахиц гарсан байна.